

“ХААН СОЁМБО АУДИТ”- ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/116/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](#)
Хөвсгөл аймаг
2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](#)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](#)

Ахлах аудитор: С.Гансүх
Утас: 86479090 Цахим хаяг: [gansukhsa@audit.gov.mn](#)

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: [info@khaansoyomboaudit.mn](#)

Гүйцэтгэсэн аудитор: Д.Отгонбаяр
Утас: 99385356 Цахим хаяг:
[khaan.soyombo.audit@gmail.com](#)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.24 № 1/115
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААН-ҮҮР СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ А.РАДНААБАЗАР ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд 56,310.0 мянган төгрөгийн утасгүй интернэтийн сүлжээ байгуулах хөрөнгө оруулалтын ажил хийгдэж ашиглалтанд оруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төсвийн гүйцэтгэл, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 5,845.4 мянган төгрөгийн 4 зөрчил илрүүлж, илэрсэн зөрчлүүдэд зөвлөмж, худалдан авах ажиллагаатай холбоотой 14,272.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

Цагаан-Үүр сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал нь Боловсролын газрын даргатай 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 8 хөтөлбөр, 93 арга хэмжээний хүрээнд 76.6 хувийн хэрэгжилттэй дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

6700021329

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>463,365,754.55</u>	<u>444,652,383.03</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	99,846,754.26	53,537,492.38
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	99,846,754.26	53,537,492.38
3121	Төгрөг	99,846,754.26	53,537,492.38
31211	Төрийн сангийн харилцах	99,846,754.26	53,537,492.38
33	АВЛАГА	1,477,461.00	15,892.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,477,461.00	15,892.00
35	БАРАА МАТЕРИАЛ	362,041,539.29	391,098,998.65
351	Түүхий эд материал	18,183,070.00	16,976,570.00
35110	Тусгай зориулалттай материал	16,804,350.00	16,804,350.00
35130	Эм боох материал	1,378,720.00	172,220.00
354	Хангамжийн материал	343,858,469.29	374,122,428.65
35410	Бичиг хэргийн материал	1,380,100.00	4,649,230.00
35420	Аж ахуйн материал	2,671,000.00	6,947,100.00
35440	Түлш, шатах тослох материал	54,956,250.15	34,970,265.51
35450	Барилгын засварын материал	769,100.00	1,567,800.00
35460	Хүнсний материал	34,347,225.11	55,580,173.11
35470	Бусад хангамжийн материал	249,734,794.03	270,407,860.03
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>718,630,652.27</u>	<u>858,742,124.93</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	718,630,652.27	858,742,124.93
392	Биет хөрөнгө	641,647,652.19	782,699,124.81
39201	Барилга, байгууламж, орон сууц	351,395,213.33	351,395,213.33
39202	Хуримтлагдсан элэгдэл	-91,379,457.16	-111,278,642.69
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,800,000.00	79,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-22,763,888.95	-4,433,333.32
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	537,642,010.20	551,651,814.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-243,720,255.23	-180,820,138.82
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	96,214,957.35	37,708,655.72
39208	Хуримтлагдсан элэгдэл	-76,217,361.31	-17,307,844.21

39214	Бусад үндсэн хөрөнгө	60,881,382.06	49,312,811.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	-46,488,229.82	-38,068,106.22
39216	Дуусаагүй барилга, байгууламж	00.00	41,797,894.00
39217	Ном	46,283,281.72	22,940,801.42
393	Биет бус хөрөнгө	76,983,000.08	76,043,000.12
39301	Програм хангамж	5,737,000.00	5,737,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,916,999.92	-3,856,999.88
39303	Бусад биет бус хөрөнгө	74,163,000.00	74,163,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,181,996,406.82</u>	<u>1,303,394,507.96</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>87,954,782.95</u>	<u>99,967,986.85</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	27,748,576.95	61,011,032.85
412	Богино хугацаат зээлийн өглөг	24,790,794.00	52,945,746.00
4121	Төгрөг	24,790,794.00	52,945,746.00
41211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	24,790,794.00	52,945,746.00
413	Өглөг	2,957,782.95	8,065,286.85
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,417,782.95	8,065,286.85
4136	Бусад өглөг	1,540,000.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,540,000.00	00.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	60,206,206.00	38,956,954.00
422	Урт хугацаат зээл	60,206,206.00	38,956,954.00
4221	Төгрөг	60,206,206.00	38,956,954.00
42211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	60,206,206.00	38,956,954.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,094,041,623.87</u>	<u>1,203,426,521.11</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,094,041,623.87	1,203,426,521.11
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	450,514,427.06	450,514,427.06
51101	Өмч: - төрийн	450,514,427.06	450,514,427.06
512	Хуримтлагдсан үр дүн	392,812,962.70	502,197,859.94
51210	Өмнөх үеийн үр дүн	392,812,962.70	392,812,962.70
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	109,384,897.24
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	250,714,234.11	250,714,234.11

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,181,996,406.82</u>	<u>1,303,394,507.96</u>
---	--	--------------------------------	--------------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,816,145,052.40	2,613,098,605.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	86,014,852.40	231,220,705.20
120	Нийтлэг татварын бус орлого	86,014,852.40	231,220,705.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	86,014,852.40	231,220,705.20
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,245,100.00	1,880,500.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ	83,769,752.40	218,376,739.20
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ	00.00	10,963,466.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,730,130,200.00	2,381,877,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,613,332,900.00	2,246,877,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,613,332,900.00	2,246,877,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	116,797,300.00	135,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	116,797,300.00	135,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,645,811,601.78	2,501,644,263.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,645,811,601.78	2,501,644,263.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,587,467,632.78	2,440,308,677.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,115,100,685.65	1,708,874,270.01
210101	Үндсэн цалин	778,906,759.55	1,087,953,160.07
210102	Нэмэгдэл	289,995,209.10	566,531,816.40
210104	Урамшуулал	46,198,717.00	54,389,293.54
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,906,433.75	210,463,411.46
210201	Тэтгэврийн даатгал	96,161,738.62	143,673,272.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,212,110.57	17,142,994.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,881,688.41	8,561,597.94
210204	Ажилгүйдлийн даатгал	2,155,878.98	8,247,724.05
210205	Эрүүл мэндийн даатгал	21,495,017.17	32,837,823.09

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,930,165.17	142,768,153.90
210301	Гэрэл, цахилгаан	34,297,095.16	37,780,003.90
210302	Түлш, халаалт	54,483,070.01	104,988,150.00
210303	Цэвэр, бохир ус	150,000.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,332,501.00	23,898,415.50
210401	Бичиг хэрэг	2,877,200.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	20,364,801.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,090,500.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	23,898,415.50
2105	Нормативт зардал	100,833,944.00	104,737,266.00
210502	Хоол, хүнс	100,833,944.00	104,737,266.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,000,000.00	7,288,800.00
210604	Урсгал засвар	12,000,000.00	7,288,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,530,100.00	19,281,454.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,175,100.00	1,740,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,355,000.00	17,540,954.05
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	95,833,803.21	222,996,906.67
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,408,599.00	82,878,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,667,350.00	14,769,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	73,757,854.21	125,349,406.67
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,343,969.00	61,335,586.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,343,969.00	61,335,586.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	58,343,969.00	61,335,586.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>170,333,450.62</u>	<u>111,454,341.61</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	00.00	00.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	2,069,444.37
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	2,069,444.37
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-2,069,444.37
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>170,333,450.62</u>	<u>109,384,897.24</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	450,514,427.06	445,126,384.63	-123,193,681.01	772,447,130.68
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	194,412,150.52	194,412,150.52
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	450,514,427.06	445,126,384.63	71,218,469.51	966,859,281.20
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	100,524,220.41	100,524,220.41
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	450,514,427.06	250,714,234.11	392,812,962.70	1,094,041,623.87
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	450,514,427.06	250,714,234.11	392,812,962.70	1,094,041,623.87
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	450,514,427.06	250,714,234.11	392,812,962.70	1,094,041,623.87
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	109,384,897.24	109,384,897.24
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	450,514,427.06	250,714,234.11	502,197,859.94	1,203,426,521.11

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,732,375,300.00</u>	<u>2,383,758,400.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,245,100.00	1,880,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,245,100.00	1,880,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,245,100.00	1,880,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,245,100.00	1,880,500.00

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,730,130,200.00	2,381,877,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,613,332,900.00	2,246,877,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,613,332,900.00	2,246,877,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	116,797,300.00	135,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	116,797,300.00	135,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,598,078,538.40</u>	<u>2,357,015,661.88</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,598,078,538.40	2,357,015,661.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,527,336,038.40	2,288,049,261.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,116,562,254.65	1,706,236,121.63
210101	Үндсэн цалин	749,271,935.65	1,044,911,681.98
210102	Нэмэгдэл	318,473,117.00	606,888,714.40
210104	Урамшуулал	48,817,202.00	54,435,725.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	139,906,433.75	211,639,990.84
210201	Тэтгэврийн даатгал	93,684,233.75	143,884,690.84
210202	Тэтгэмжийн даатгал	11,664,500.00	16,948,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,331,400.00	8,474,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,332,800.00	8,474,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,893,500.00	33,857,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	104,797,300.00	125,000,000.00
210301	Гэрэл, цахилгаан	31,297,300.00	36,000,000.00
210302	Түлш, халаалт	70,000,000.00	85,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,500,000.00	4,000,000.00
2105	Нормативт зардал	100,571,600.00	118,339,400.00
210502	Хоол, хүнс	100,571,600.00	118,339,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,000,000.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	12,000,000.00	10,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,555,100.00	22,603,454.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,175,100.00	1,740,500.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,380,000.00	20,862,954.05
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,943,350.00	94,230,295.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,276,000.00	79,430,600.36
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,667,350.00	14,799,695.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,742,500.00	68,966,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,742,500.00	68,966,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	70,742,500.00	68,966,400.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>134,296,761.60</u>	<u>26,742,738.12</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	34,955,200.00	73,052,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	34,955,200.00	73,052,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	34,955,200.00	73,052,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	34,955,200.00	73,052,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-34,955,200.00</u>	<u>-73,052,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	99,341,561.60	-46,309,261.88
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	505,192.66	99,846,754.26
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	99,846,754.26	53,537,492.38

2.5 Аудит хийсэн улсын төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	99,846,754.26	(99,846,754.26)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,348,603,700.00	2,295,067,661.88	53,536,038.12	97.72
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,348,603,700.00	2,295,067,661.88	53,536,038.12	97.72
4	Бараа, үйлчилгээний зардал	2,279,637,300.00	2,226,101,261.88	53,536,038.12	97.65
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,749,427,100.00	1,706,236,121.63	43,190,978.37	97.53
6	Үндсэн цалин	1,150,259,700.00	1,044,911,681.98	105,348,018.02	90.84
7	Нэмэгдэл	564,183,100.00	606,888,714.40	(42,705,614.40)	107.57

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

9	Урамшуулал	34,984,300.00	54,435,725.25	(19,451,425.25)	155.60
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	218,678,500.00	211,639,990.84	7,038,509.16	96.78
12	Тэтгэврийн даатгал	148,701,300.00	143,884,690.84	4,816,609.16	96.76
13	Тэтгэмжийн даатгал	17,494,300.00	16,948,900.00	545,400.00	96.88
14	ҮОМШӨ ний даатгал	8,747,200.00	8,474,400.00	272,800.00	96.88
15	Ажилгүйдлийн даатгал	8,747,200.00	8,474,400.00	272,800.00	96.88
16	Эрүүл мэндийн даатгал	34,988,500.00	33,857,600.00	1,130,900.00	96.77
30	Нормативт зардал	118,339,400.00	118,339,400.00	-	100.00
32	Хоол, хүнс	118,339,400.00	118,339,400.00	-	100.00
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	36,217,100.00	34,800,454.05	1,416,645.95	96.09
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,740,500.00	1,740,500.00	-	100.00
49	Мэдээллийн технологийн зардал	34,476,600.00	33,059,954.05	1,416,645.95	95.89
53	Бараа үйлчилгээний бусад зардал	156,975,200.00	155,085,295.36	1,889,904.64	98.80
54	Бараа үйлчилгээний бусад зардал	142,097,200.00	140,285,600.36	1,811,599.64	98.73
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,878,000.00	14,799,695.00	78,305.00	99.47
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,966,400.00	68,966,400.00	-	100.00
70	Бусад урсгал шилжүүлэг	68,966,400.00	68,966,400.00	-	100.00
74	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	68,966,400.00	68,966,400.00	-	100.00
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,348,533,700.00	2,248,758,400.00	99,775,300.00	95.75
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,246,877,900.00	2,246,877,900.00	-	100.00
99	Улсын төсвөөс санхүүжих	2,246,877,900.00	2,246,877,900.00	-	100.00
110	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	101,655,800.00	1,880,500.00	99,775,300.00	1.85
111	Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,775,500.00	1,880,500.00	(105,000.00)	105.91
113	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	99,880,300.00	-	99,880,300.00	-
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	99,846,754.26	(99,846,754.26)	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	53,537,492.38	(53,537,492.38)	-
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-

130	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	71	71	-	100
134	Удирдах ажилтан	1	1	-	100
135	Гүйцэтгэх ажилтан	46	46	-	100
136	Үйлчлэх ажилтан	24	24	-	100

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨ Ө	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	135,000,000.00	135,000,000.00	-	100.00
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	135,000,000.00	135,000,000.00	-	100.00
4	Бараа, үйлчилгээний зардал	135,000,000.00	135,000,000.00	-	100.00
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	125,000,000.00	125,000,000.00	-	100.00
18	Гэрэл цахилгаан	36,000,000.00	36,000,000.00	0.00	100.00
19	Түлш, халаалт	85,000,000.00	85,000,000.00	-	100.00
20	Цэвэр, бохир ус	4,000,000.00	4,000,000.00	-	100.00
34	Эд хогшил худалдан авах	10,000,000.00	10,000,000.00	-	100.00
38	Урсгал засвар	10,000,000.00	10,000,000.00	-	100.00
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	135,000,000.00	135,000,000.00	-	100.00
103	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	135,000,000.00	135,000,000.00	-	100.00
104	Орон нутгийн төсвөөс	135,000,000.00	135,000,000.00	-	100.00
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
130	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-

13 3	АЖИЛЛАГСДЫН ТОО	71	71	-	100
13 4	Удирдах ажилтан	1	1	-	100
13 5	Гүйцэтгэх ажилтан	46	46	-	100
13 6	Үйлчлэх ажилтан	24	24	-	100

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар 14,272.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 5,845.4 мянган төгрөгийн 4 зөрчил илэрсэнд 4 зөвлөмж өгсөн.

5.1 Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой алдаа зөрчил илрээгүй байна.

5.2 Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.3 5.3 Албан шаардлага гараагүй

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой

Илрүүлэлт:

Цагаан-Үүр сумын ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2024 оны 07 сарын 22-ны өдрийн Б/29 тоот тушаалаар нягтлан бодох бүртгэлийн ажилтанд 1,471.0 мянган төгрөгийн урамшууллыг олгохдоо ажлын үр бүтээлийг үнэлсэн хангалттай баримтыг үндэслээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-тай нийцээгүй ба санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

Зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулахдаа ажлын үр бүтээлийг үнэлж байх

Илрүүлэлт:

Тайлант онд цалингийн зардлаас ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал руу 1,176.6 мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2023 оны 211 тушаалаар баталсан "Төсвийн эдийн засгийн зарлагын ангилал ашиглах заавар"-ыг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

Зөвлөмж:

Төсвийг батлагдсан эдийн засгийн ангилалын дагуу зарцуулах

Илрүүлэлт:

Орон нутгийн төсвийн төлөвлөлтийг бодитой хийгээгүйгээс Хөвсгөл Эрчим хүч ХХК-д 3,197.8 мянган төгрөгийн өр үүсэж, тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлэх

Зөвлөмж:

Эхний хагас жилд багтаан өр төлбөрийг шийдвэрлэж барагдуулах, төсвийн төсвөө үнэн зөв тооцож төсвөө батлуулж хэвших

Илрүүлэлт:

Тайлант онд **дотуур байрны хүүхдийн хоолны материал нийлүүлэх** багцад **97,931.5** мянган төгрөгийн үнийн саналаар Тэвгэр асга ХХК шалгарч гэрээ байгуулан ажилласан **боловч** бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлж, гэрээний үнийн дүнгээс **14,272.9 мянган** төгрөгөөр хэтрүүлэн худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.11-д "гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөр тооцоог гүйцэтгэх" гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

Зөвлөмж: Хууль тогтоомжийн дагуу гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөр тооцоо хийж байх

2. Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт:

Тус байгууллага нь Ахмадын тухай хуулийн холбогдох заалтын дагуу ахмадын сан байгуулж, жилийн төсөвтөө төлөвлөж батлуулаагүй байна. Энэ нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална", Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ахмадын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хууль журмын дагуу байгууллагын төсвийн төсөлдөө ахмадын санг төлөвлөн батлуулж ажиллах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргаж, fas.audit.mn системд оруулж, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	/Мянган төгрөгөөр/	
		Үүнээс	

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодох бүртгэлийн ажилтанд ажлын үр бүтээлийг үнэлэхгүй санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтэд үндэслэн балансын урамшуулал гэж олгосон.	1	1,471.0.0					1	1,471.0.0
Төсвийн эдийн засгийн ангилал зөрчин гүйлгээ хийсэн	1	1,176.6					1	1,176.6
Гэрээний нөхцөл, үнийн дүнгээс хэтрүүлэн худалдан авалт хийсэн	1	14,272.9			1	14,272.9		
Орон нутгийн төсвийг дутуу тооцоолж төсвөө батлуулснаас өр үүссэн	1	3,197.8					1	3,197.8
Дүн	4	20,118.3			1	14,272.9	3	5,845.4

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Ахмадын тухай хуулийн дагуу ахмадын сан байгуулж ажиллаагүй.	1	0					1	0
Дүн	1	0					1	0